ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 25 өдөр Дугаар А/34 Өвт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хөдөөд аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил болгон зарлах тухай" 2020 оны 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил"-ийн ажлыг сумын хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Л.Батчулуун-Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга: Э.Бадамханд-Хөдөө аж ахуйн тасгийн хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан мэргэжилтэн
Гишүүд: О.Отгонтуяа-Санхүүгийн албаны дарга
Б.Янжиндулам-Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Н.Долгормаа- Нийгмийн ажилтан
П.Аюушжав-Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч
Г.Сугар-Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
Ш.Бумандолгор-Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
Т.Жамъянжав-1 дүгээр багийн Засаг дарга
Д.Даваацэрэн-2 дугаар багийн Засаг дарга
С.Төмөр-3 дугаар багийн Засаг дарга
Г.Пүрэвтогтох-4 дүгээр багийн Засаг дарга
Л.Балжинням-5 дугаар багийн Засаг дарга

2. "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих" жилийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцон ажиллахыг ажлын хэсэг (Л.Батчулуун)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/